

**Дундговь аймгийн Засаг даргын Батлан хамгаалахын сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан**

2022.11.30


Аймгийн Засаг даргын Батлан хамгаалахын сайдтай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

**НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ**

Аймгийн Засаг даргын Батлан хамгаалахын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Цэргийн штабаас ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 31 үүргийг хүлээж, хэрэгжүүлэн ажилласнаар жилийн эцсийн байдлаар 90.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 25 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээ 0 хувьтай байна.



## ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.

“Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн арга хэмжээнд 1579 иргэн хамрагдсан.



Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан арга хэмжээнд удирдамжийн дагуу 8-н төрлийн тэмцээн зохион байгуулж нийт 65 сурагч оролцож үүргээ 100 хувь хэрэгжүүлсэн. Батлан хамгаалахын яамнаас Улсын аварга шалгаруулах тэмцээний зааврын дагуу 13 сурагчийг бэлтгэн Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд Батлан хамгаалахын сайдын нэрэмжит цэрэг спортын “Дөл-2022” тэмцээнд амжилттай оролцож 100 хувийн гүйцэтгэлтэй оролцож ирсэн. Улс, аймагт болсон “Дөл -2022” тэмцээнд оролцсон сурагчдын жигд хувцасаар хангах болон бусад зардалд 11.2 сая төгрөг зарцуулсан.



Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх салааны үүрэгтэн 33 иргэний сургалтыг амжилттай явууллаа.



### ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Дундговь аймагт Батлан хамгаалах туслах нийгэмлэг байдаг боловч хариуцаж байсан удирдлага тэтгэвэрт гарсан тул одоогоор дараагийн хүн томилогдоогүй учраас Цэргийн штаб, батлан хамгаалахад туслах олон нийтийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ тасарсан байна.

### ДӨРӨВ: САНАЛ, ДҮГНЭЛТ


Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.3.2-т заасны дагуу 90.9 хувь байгаа нь "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Батлан хамгаалахын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг журмаар батлагдсан загварын дагуу шаардлага хангасан төлөвлөлтийг хийж батлуулахад анхаарах шаардлагатай байна.


Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг

